


Сэтгүүлч таны эрх зөрчигдвөл...

2011.02.18
Улаанбаатар хот

Цагдан хяналт


Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн гол зөрчил цензурээр дамжин илэрдэг.

- Төрийн цагдан хяналт – хуулиар дамжин илэрдэг
- Захиргааны цагдан хяналт
- Редакцийн цагдан хяналт
- Өөрийн цагдан хяналт
 - Судалгаанд хамрагдсан 215 сэтгүүлчдийн 105 нь буюу 48,8% нь эрэн сурвалжилсан, асуудал хөндсөн баримт, материал нийтэлж, нэвтрүүлэхээс айж өөртөө цензур тавьдаг



Цагдан хяналт ямар түвшинд байна вэ?

- Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн гол зөрчил цензурээр дамжин илэрдэг. Цензурыг манайд 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хориглосон ч хэрэг дээрээ бүх төрлийн цензур бодитой хэвээр байна.
- Судалгаанд оролцсон 215 сэтгүүлчийн 60,4% буюу 130 сэтгүүлч нийтлэл, нэвтрүүлгээсээ болж нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэсэн гомдолтой тулгарсан байна. 130 сэтгүүлчийн 50,8% буюу 66 нь сүрдүүлэг заналхийлэлд өртөж, 40% буюу 52 нь дарамтанд орсон бол 23% буюу 30 сэтгүүлчид иргэний хэрэг үүсгэн шалгажээ.



Сүрдүүлэг дарамт

- Төрийн байгууллага, албан тушаалтан дуудаж загнах
- Цагдаа, тагнуул, хүчний байгууллагаас дуудсан
- Олны өмнө доромжлох, дарамт үзүүлэх
- Радио, телевизийн лиценз хураахаар сүрдүүлэх
- Баривчлана, хорино гэж сүрдүүлэх

Амь нас, эрүүл мэндэд халдах

1. Заналхийлэх
2. Сэтгэл санааны дарамт
3. Зодож бэртээх
4. Хулгайлагдах, барьцаалах
5. Аллага, бусад

Орлого, эд хөрөнгөд халдах

- Эд хөрөнгө хураах
- Ажлын багаж хэрэгсэлд халдах
- Өөрт таалагддаг сэтгүүлчийг эсвэл өөрт ойр, эсвэл өөрийн эзэмшилд байдаг ХМХ-д зар сурталчилгааг өгөх
- Зар сурталчилгааг ялгавартай өгөх

Хуулийг ашиглаж эрх зөрчих

- Төрийн нууцын хуулийг ашиглах
- Нэр төр, гүтгэлэгтэй холбоотой Эрүүгийн хуулийн хатуу чанга заалтыг ашиглах
- Тусгай зөвшөөрөл хураах
- Хууль тогтоомжид нийцээгүй, сэтгүүлч, ХМХ-ийн эрхийг хязгаарласан дүрэм журам гаргах

Эрх чөлөөнд халдах

- Үзлэг, нэгжлэг хийх
- Хорих
- Албадан саатуулах
- Баривчлах

Мэдээлэл олж авахтай холбогдох

- Нээлттэй арга хэмжээ, хурал, цуглаанаас хөөх,
- Нутаг дэвсгэр, албан газар, байгууллага, байр сав, барилга байгууламжид нэвтрүүлэхгүй байх
- Сурвалжлагчийн итгэмжлэх үнэмлэх олгохгүй байх, хураан авах, хууль бусаар шаардах
- Зураг авах, бичлэг хийх боломж олгохгүй саатуулах
- Мэдээлэл хүссэн үед татгалзах, бүрэн бус, худал хариу өгөх гэх мэт

Мэдээлэл түгээхтэй холбоотой

- Сонин хэвлэхгүй байх үүрэг даалгавар өгөх
- Сонин хэвлэлийн түгээлтийг саатуулах, хязгаарлах
- Өргөн нэвтрүүлгийг зогсоох, саатуулах, хязгаарлах

Эх сурвалж илчлэх албадлага

- Сэтгүүлчид бусад иргэдийн адил мэдээлэлд нэвтрэх эрхтэй бөгөөд мэдээллийн эх сурвалжаа нууцлах нь сэтгүүлчийн онцгой үүрэг гэж үздэг.
- Сэтгүүлчдийг мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардах, татгалзсаных нь төлөө торгох, шоронгоор айлган сүрдүүлэх, заналхийлэх байдлаар эх сурвалжийг хэлүүлдэг.

Редакциас сэтгүүлчийн эрхийг зөрчих

- Эзэд, эрхлэгч, редакторууд сэтгүүлчийн бичиж бэлтгэсэн материалын агуулгыг хянах
- Бичиж бэлтгэсэн материалын тодорхой зорилгоор нийтлэхгүй, нэвтрүүлэхгүй байх
- "Болохгүй" гэж үзэж буй хэсгээ хасахыг шаардах
- Бичиж бэлтгээгүй материалд нэрээ дурдахыг шаардах
- Цалин хасах, ажлаас халах зэргээр арга хэмжээ авах, шийтгэл ногдуулах
- Бусад



Нийтийн МХ-ийн редакцийн эрхийн зөрчил

1. Цагдан хяналт
2. Редакцийн мэргэжлийн үйл ажиллагаанд хараат бус байдалд төр,засгийн байгууллага, хэвлэн нийтлэгчдийн зүгээс хөндлөнгөөс оролцох
3. Өргөн нэвтрүүлгийг үйл ажиллагааг хууль бусаар зогсоох
4. Сонин хэвлэлийг хаах
5. Шаардлагагүй байхад байнга татвар, НД болон бусад шалгалт хийлгэх



**ДЭЭРХ ЗӨРЧИЛ ГАРМАГЦ
ТА ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?**



Хэн нэгэн дуудсан даруйд ОЧИХООСОО ӨМНӨ

1. Ямар учраас дуудсан үндэслэл, шалтгааныг асуух
2. Ямар хугацаанд очиж болох хуулийн хугацаатай талаар тодруулах
3. Заавал өмгөөлөгчийн хамтаар байцаалт, мэдүүлэг өгөх тухай мэдэгдэх
4. “Глоб” руу хандах, тусламж авах
5. Үйл явдлын өрнөлийг идэвхтэй хянах хэрэгтэй

GLOBE INTERNATIONAL ANNUAL REPORT



MEDIA FREEDOM MONGOLIA REPORT

Хэвлэлийн эрх чөлөөний тайлан

Хүний эрхийн төлөв байдлын ээлжилт дүгнэлт, хэлэлцүүлэг



UNIVERSAL PERIODIC REVIEW (UPR) MONGOLIA 2010

www.upr-mongolia.mn

ИЛ ХЭЛ ЭС БӨГӨӨС ЭРХ ЧӨЛӨӨ УЛАМ ХУМИГ ДАНА!



SELF ALERTING

"Шударга ёсны од"

"Хүний эрхийн мэдээллээр дамжуулан иргэнийг чадавхжуулах нь"

"Глоб Интернэшнл" төрийн бус байгууллага нь 1999 оны 3-р сард Улаанбаатар хотноо байгуулагдсан, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, ашгийн төлөө бус байгууллага юм.

"Глоб Интернэшнл" ТББ-ын тэргүүнээр сэтгүүлч Х.Наранжаргал, удирдах зөвлөлийн гишүүдээр сэтгүүлч Х.Цэвэлэ, До.Чулуунбаатар, Б.Галаарид, орчуулагч Д.Аюуш зэрэг хэвлэл мэдээлэл, хууль эрх зүйн салбарт нэр хүндтэй хүмүүс сонгогдон ажилладаг.

Эрхэм зорилго

Мэдээлэл, мэдлэгийн хүчийг түгээж, Монголд ардчилал, иргэний нийгмийг хөхиүлэн дэмжих,

Алс хэтийн хараа

Ардчилсан соёл төлөвшсөн нийгэм, мэдээлэлтэй, чадавхитай иргэд

Уриа: Мэдлэг бол Хүч

Үнэт зүйлс:

- Хараат бус
- Шударга ёс
- Ардчилсан
- Ялгаварлан гадуурхалтаас ангид
- Авлигагүй

Стратегийн үзэл баримтлал

Мэдээлэл бол мэдлэгийн үндэс юм. Мэдээлэл, мэдлэгтэй иргэд хүчирхэг байж, төрийн хэрэгт шууд оролцож, нийгмийн хөгжил дэвшлийг залах чадавхитай болно. Ингэвэл Монгол Улсын Үндсэн Хуулиар баталгаажуулсан ардчилсан, иргэний нийгмийг цогцлуулан бүтээж чадна. Иргэд санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэлтэй байх нь хүний эрхийг дээдэлсэн ардчилсан, иргэний нийгмийг төлөвшүүлэх, бэхжүүлэх, гүнзгийрүүлэх, иргэдэд үйлчилдэг эрүүл саруул нийгэм оршин тогтнохын нэг үндэс юм.

Стратегийн үндсэн зорилго

"Глоб Интернэшнл" төрийн бус байгууллагын стратегийн үндсэн зорилго нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл, харилцааны шинэ технологи зэрэг мэдээлэл түгээх боломжийн бүх аргаар иргэдийг мэдээлэлтэй болоход туслахад оршино.

Зорилтот бүлэг

Олон нийт, хэвлэл мэдээлэл

Үйл ажиллагааны хэлбэр:

- Эрх зүйн шинэтгэл
- Судалгаа, дүн шинжилгээ хийх
- Хэвлэл мэдээллийн аян зохион явуулах
- Сургалт, бусад арга хэмжээ зохион байгуулах
- Мониторинг хийх
- Бусад үр нөлөөтэй арга хэлбэр

Стратегийн зорилт, үндсэн хөтөлбөр:

1. Хяраат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь
2. Засаглал, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих нь
3. Олон нийтийг чадавхжуулах нь



Гишүүн байгууллага



INTERNEWS



ХЭВЛЭЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Шуурхай мэдээ хүлээн авах сувгууд

Yahoo messenger:



alert_mon@yahoo.com

Гар утас:



99 127 127

99 193 327

Шуурхай мэдээ хүлээн авах сувгууд

Онлайн:



**www.
globeinter.org.mn/s
elfalerting**

Ажлын утас:



**11 - 324764
11 - 324627**


ШУУРХАЙ МЭДЭЭ ХҮЛЭЭН АВАХ СУВГУУД

E-mail:




globe@globeinter.org.mn
globenews@globeinter.org.mn
globemon@gmail.com

Хаяг:



**Улаанбаатар хот,
6-р хороо, Дипломат 95
цогцолбор, 6-р орц,
70 тоот**

Анхаарал тавьсанд баярлалаа



www.globeinter.org.mn

Утас: 324627, 324764